



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар: А/479

Арвайхээр сум

**Тендер хүчингүй болгох, гэрээ
шууд байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 86 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАОНӨГ/202306063/02/01 урилгын дугаартай Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн Спорт заалны дээврийн засварын ажилд шаардлагад нийцсэн нэг ч оролцогч үнийн саналаа ирүүлээгүй тул хүчингүй болгосугай.

2. Тус тендерийг 3-аас доошгүй аж ахуйн нэгжид үнийн санал хүргүүлж гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0936

D:My Doc. Zahiramj. Zasag darga